



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 1/95

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 11 дүгээр дүгнэлтийн дагуу Есөнзүйл сумын төвөөс орон нутгийн А-0301 Засмал зам хүртэлх 10.0 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Өвөрхангай, Есөнзүйл сум/ ажлын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг 5.200.000 (таван сая хоёр зуун мянга) төгрөгөөр “Эрчим-Электрик” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан зураг төсөв боловсруулах явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.



ДАРГА

Ц.ГАНБОЛД

012100103

D: My Doc. Tushaal. ZDTG